



Ерөнхийлөгч Томас С.Монсон

# Хайр бол сайн мэдээний үндсэн зарчим

*Хэрэв бид энэхүү мөнх бус амьдралын аянд хамт аялж буй хүмүүсээ хайрлахгүй юм бол Бурханыг чин үнэнээсээ хайрлаж чадахгүй.*

**Х**айрт ах, эгч нар минь, бидний Аврагч хүмүүний дунд тохинуулах үед нэгэн хуульч Түүнийг сорьж, “Багш аа, хууль дахь агуу тушаал нь аль вэ?” хэмээн асуужээ.

Матайн номонд Есүс:

“Чи бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюунаараа өөрийн Бурхан Эзэнээ хайрла.

Энэ бол агуу нь бөгөөд хамгийн чухал тушаал мөн.

Удаах нь “Чи хөршөө өөрийн адил хайрла”<sup>1</sup> хэмээн хариулжээ.

“Эдгээрээс илүү өөр агуу тушаал байхгүй”<sup>2</sup> гэсэн Аврагчийн үгсээр Марк уг түүхийг төгсгөсөн байдаг.

Хэрэв бид энэхүү мөнх бус амьдралын аянд хамт аялж буй хүмүүсээ хайрлахгүй юм бол Бурханыг чин үнэнээсээ хайрлаж чадахгүй. Үүн лүгээ адил, хэрэв бид бүгдийн Эцэг Бурханаа хайрлаж чадахгүй бол

хөршөө жинхэнэ ёсоор хайрлаж чадахгүй. Төлөөлөгч Иохан бидэнд “Бурханыг хайрладаг нэгэн нь мөн ах дүүгээ хайрлах ёстой. Бид энэ тушаалыг Түүнээс авсан билээ”<sup>3</sup> хэмээн хэлсэн юм. Бид бүгд Тэнгэрлэг Эцэгийнхээ сүнсэн хүүхдүүд учраас ах, эгч дүүс билээ. Бид энэхүү үнэнийг үргэлж санаж явах юм бол Бурханы бүх хүүхдийг хайрлах нь илүү амар хялбар байх болно.

Чухамдаа хайр нь сайн мэдээний хамгийн чухал хэсэг бөгөөд Есүс Христ бидний төгс үлгэр жишээ юм. Түүний амьдрал хайрын өв байлаа. Тэр өвчтөнүүдийг эдгээж, дарлагдсдыг өргөн дэмжиж, нүгэлтнүүдийг аварсан юм. Эцэст нь уурлаж хилэгнэсэн хүмүүс Түүний амийг хөнөөсөн ч “Аав аа, тэднийг уучлаач. Учир нь тэд юу хийж байгаагаа мэдэхгүй байна”<sup>4</sup> гэсэн мөнх бус амьдрал дахь хамгийн дээд

өрөвч сэтгэлийн мөн хамгийн дээд хайрын жишээ болсон үгс Голгота гүвээн дээрээс цуурайтсан юм.

Эелдэг дөлгөөн зан, тэвчээр, амин хувиа үл хичээх үзэл, ойлголт, уучлал зэрэг хайрын илрэл болсон олон зан чанар байдаг. Бидний бүхий л үйлдлүүдэд илэрдэг эдгээр болон эдгээртэй төстэй бусад зан чанар нь бидний зүрх сэтгэл дэх хайрыг олж харахад бусдад туслах болно.

Бидний хайр нь бие биетэйгээ харилцах өдөр тутмын харилцаанаас ихэвчлэн харагддаг. Хайраа үзүүлэх хамгийн чухал арга зам бол хэн нэгний хэрэгцээг олж мэдэн, түүнд туслах явдал юм. Би дараах яруу найргийн богинохон шүлгэн дэх хайрын тухай санааг үргэлж үнэлсээр ирсэн билээ:

*Хэн нэгний хэрэгцээг мэдэж  
чадаагүй  
Харалган нүднийхээ төлөө  
Харанхуй шөнөөр уйллаа би.  
Харин илүү эелдэг байсныхаа  
төлөө  
Харамсал шаналлын  
мэдрэмжийг  
Хэзээ ч би мэдэрч байгаагүй.<sup>5</sup>*

Мөн би саяхан агуу хайрын тухай үнэхээр сэтгэл догдлом нэгэн түүхийг олж сонслоо. Энэ нь санамсаргүй тохиолдол байсан байна. Энэ явдал ажил эрхлэлтийн боломж тун хомсдсон эдийн засгийн их уналтын үед буюу 1933 онд Нэгдсэн Улсын зүүн нутагт болсон ажээ. Арлэн Бийсэкэр дөнгөж ахлах сургуулиа төгсөөд ажилд орох гэж удаан хөөцөлдсөний эцэст оёдлын үйлдвэрт

оёдолчноор оржээ. Оёдлын үйлдвэрийн ажилчдад цалинг зөвхөн ямар ч гологдолгүй оёсон хувцас бүрээр тооцож, өдөрт нь олгодог байж. Тэд хэдий чинээ олон хувцас оёно, төдий чинээ их цалин авдаг байв.

Арлэн оёдлын үйлдвэрт ажилд орсныхоо дараахан, нэгэн өдөр түүнийг эргэлзүүлж, урам хугарахад хүргэсэн нэгэн сорилттой тулгарчээ. Тэр оёдлын машиныхаа ард суугаад буруу оёсон хувцасныхаа утсыг ханзлах гэж үйлээ үзэж байв. Түүнд хэн ч туслахгүй нь илт байсан бөгөөд хүн болгон л чадахынхаа хэрээр аль болох ахиухан хувцас оёх гээд толгой өндийлгөх завгүй ажиллаж байлаа. Арлэн өөрийгөө унхиагүй, найдваргүй гэж бодоод чимээгүйхэн үйлж эхэлжээ.

Арлэний эсрэг талд Бэрнис Рок гэгч оёдолчин суудаг байж. Тэр түүнээс хэдэн насаар эгч, илүү туршлагатай ажээ. Арлэний сэтгэл гонсгор байхыг Бэрнис хараад хийж байсан ажлаа орхиод түүний хажууд сууж, эелдгээр зөвлөгөө өгч эхэлжээ. Тэр Арлэнийг итгэлтэй болж, хувцсаа зөв оёж дуусгах хүртэл түүнтэй хамт байсан гэнэ. Дараа нь Бэрнис оёдлын машин руугаа буцаж очжээ. Тэр Арлэнд тусалснаар илүү олон хувцас оёж дуусгах боломжоо алдсан байлаа.

Энэхүү хайрын нинжин сэтгэлийн ганцхан үйлдлээр Бэрнис, Арлэн хоёр насан туршийн найзууд болж, улмаар хоёул гэрлэж, үр хүүхдүүдтэй болцгоожээ. Сүмийн гишүүн Бэрнис 1950-иад оны үед Арлэнд болон түүний гэр бүлд Мормоны Ном өгчээ. Арлэн 1960 онд нөхөр, хүүхдүүдийнхээ хамт сүмийн гишүүн болж, баптисм хүртсэн юм. Хожим нь тэд Бурханы ариун сүмд лацдан холбогджээ.

Санаагаар унаж гутарсан, тусламж хэрэгтэй байсан танихгүй хүнд гар сунган туслахын тулд өөрөө хохирол хүлээсэн Бэрнисийнх шиг өрөвч нинжин сэтгэлийн ачаар амьд байгаа болон нас барсан тоо томшгүй хүн эдүгээ сайн мэдээний авралын ёслолуудыг хүртэж байна.

Бидэнд эргэн тойрныхоо хүмүүст хайр, нинжин сэтгэлээ харуулах боломж өдөр бүр гарч байдаг. Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбалл “Бидэнтэй машины зогсоол, оффис, цахилгаан шатан дотор болон бусад олон газарт тааралддаг хүмүүс бол тэднийг хайрлаж, тэдэнд үйлчилж бай хэмээн Бурханы бидэнд илгээсэн хүмүүс гэдгийг бид санаж явах ёстой. Хэрэв бид эргэн тойрныхоо хүмүүсийг ах, эгч нараа гэж үзэхгүй юм бол хүмүүсийн хоорондох ах дүүсэг ёсны тухай яриа нь бидэнд тийм ч үр нөлөөтэй биш байх болно”<sup>6</sup> хэмээн хэлжээ.

Бусдад хайраа үзүүлэх боломж нь ихэнхдээ бидэнд санамсаргүй байдлаар ирдэг. Ийм боломжийн нэгэн жишээ 1981 оны 10-р сард нэгэн сонины өгүүлэлд нийтлэгдсэн юм. Би тэр өгүүлэлд нийтлэгдсэн хайр, өрөвч нинжин сэтгэлийн тухай уншаад сэтгэл ихэд догдолсон учир өгүүлийн хайчилбарыг 30 гаруй жилийн турш хадгалж байна.

Уг өгүүлэлд Аляскийн Анкорижаас Вашингтоны Сиэттл руу замдаа буулгүй нисэх ёстой байсан 150 зорчигчтой онгоц Аляскийн алслагдсан нэг хотоос хүнд бэртсэн нэгэн хүүхдийг авахын тулд нислэгийн чиглэлээ өөрчилсөн тухай өгүүлсэн байлаа. Хоёр настай хүү гэрийнхээ ойролцоо тоглож байгаад хагарсан шилэн дээр унаснаас болж гарынхаа артерийн судсыг зүсчихжээ. Тэр хот Анкорижаас 725 километр зайтай бөгөөд нислэгийн замаас тэс өөр зүгт байсан хэдий ч хөвгүүнд туслахыг хүссэн эмч нар онцгой хүсэлт тавьснаар тэр онгоц хүүг авч, Сиэттлд хүргэж өгч, эмчлүүлэхээр замдаа саатсан аж.

Онгоц хүүгийн байгаа хотын ойролцоо газардахад эмч нар хүүг маш их цус алдаж байгаа учраас Сиэттлд хүрч чадахгүй гэж мэдэгджээ. Иймээс тэд 320 километр хол орших хамгийн ойрхон эмнэлэгтэй хот Аляскийн Жуниа руу нисэхээр шийдсэн байна.

Хүүг Жуниад хүргэж өгсний дараа нислэгийн хуваариасаа

хэдэн цаг хоцорсон онгоц Сиэттл руу нисчээ. Хэдийгээр зорчигчдын олонх нь чухал уулзалтууд болон дараагийн нислэгээсээ хоцорсон ч, тэднээс нэг нь ч гомдоллоогүй ажээ. Онгоц нислэгийн хуваариасаа олон цаг, минутаар хоцорсон ч тэд хүүд болон гэр бүлд нь туслахын тулд их хэмжээний мөнгө цуглуулсан байна.

Онгоц Сиэттлд газардах дөхөж байх үеэр хүүгийн бие сайжирч байна гэсэн мэдээг онгоцны радио холбоогоор хүлээн авсан тухай нисэгчийг мэдэгдэхэд зорчигчид бүгд баярлан, уухай хашгирчээ.<sup>7</sup>

Миний санаанд дараах судрын үгс орж ирж билээ: “Гэвч энэрэл бол Христийн цэвэр хайр, . . . мөн эцсийн өдөр үүнийг эзэмшиж байгаа хэнд боловч, түүнд сайн байх болно.”<sup>8</sup>

Ах, эгч нар аа, хайраа үзүүлэх хамгийн агуу боломжууд бидний гэр оронд байдаг юм шүү. Хайр нь гэр бүлийн амьдралын голт зүрх нь байх ёстой ч заримдаа тийм байдаггүй. Гэр бүлийн амьдралд тэвчээргүй зан, хэрүүл маргаан, гашуун нулимс дэндүү их байна. Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли: “Яагаад бидний хамгийн их хайрладаг хүмүүс бидний хахир хатуу үгсийн бай болох ёстой юм бэ? Яагаад бид заримдаа бие биенээ сэтгэл санааны ноцтой хямралд оруулж гомдоох хорон үгсийг санаатай хэлдэг юм бэ?”<sup>9</sup> хэмээн тун гунигтай асуусан байдаг. Эдгээр асуултын хариулт хүн бүрд өөр байж болох ч, шалтгаан нь тийм ч их хамаатай биш нь үнэн юм. Хэрэв бид бие биеэ хайрлах зарлигийг дагах юм бол нэг нэгэндээ эелдэг дөлгөөн, хүндэтгэлтэй хандах болно.

Зарим үед сахилгажуулах хэрэгтэй гэдэг нь мэдээж. Тиймээс бүгдээрээ хэн нэгнийг шүүмжлэх шаардлага гарвал дараа нь түүнийг хайрлах хайраа нэмэгдүүлснээ харуул гэсэн зөвлөгөө Сургаал ба Гэрээнд байдгийг санацгаая.<sup>10</sup>

Бид эргэн тойрныхоо хүмүүст хүндэтгэлтэй хандаж, тэдний бодол санаа, мэдрэмж, нөхцөл байдлын

талаар үргэлж бодож, анхаарал тавьж байх болно гэдэгт би найдаж байна. Бусдыг дорд үзэж, шүүмжлэхгүй байцгаая. Харин тэдэнд өрөвч энэрэнгүй хандаж, урам дэм өгдөг байцгаая. Бид болгоомжгүй үг, болчимгүй үйлдлээрээ бусдын итгэлийг унтраахгүй байхад анхаарах ёстой.

Уучлал, хайр хоёр ихэр мэт үргэлж хамт байх ёстой. Бидний гэр бүлүүдэд бас найз нөхдийн маань дунд гомдол, санал зөрөлдөөн байж болно. Асуудал нь хэчнээн өчүүхэн байлаа ч гэсэн үнэхээр чухал биш гэдгийг дахин хэлбэ. Асуудал нь шарх болон сэдэрч, улмаар даамжран, эцэстээ мөхөл рүү хүргэж болохгүй бөгөөд ингэх ч ёсгүй юм. Бусдыг буруу юм хийснийх нь төлөө буруутгах нь сэтгэл санааны хувьд эдгэхэд нь саад болдог. Гагцхүү уучлал л үүнийг эдгээж чадна.

Нэгэн өдөр нүдэнд дулаахан нэг эмэгтэй над дээр ирж, санамсаргүй тохиолдлоор харамсаж явдаг зүйлийнхээ талаар ярьсан юм. Дараа нь тэр нас барсан л даа. Тэр эмэгтэй олон жилийн өмнө нэгэн үе сайн найз байсан хөрш тариаланчтайгаа хэд хэдэн удаа нөхөртэйгөө нийлэн, маргалдсан ажээ. Нэг өдөр тариаланч түүнээс эдлэн газрынх нь дундуур өөрийнхөө фермд хүрэх дөт зам гаргаж болох эсэх талаар асуусан байна. Нөгөө эгч энэ тухай ярьснаа гэнэт дуугүй болж, хоолой нь чичрэн, “Монсон ах аа, би түүнд дөт зам гаргахыг зөвшөөрөөгүй. Тэр өөрийнхөө ферм рүү маш тойруу замаар явж хүрдэг байсан. Миний буруу, би харамсаж байна. Тэр нас барсан. Хөөрхий минь дээ, би түүнд

‘Уучлаарай’ гэж хэлэхийг ямар их хүсч байна гээч. Би түүнд эелдэг хандах хоёрдахь боломж гараасай хэмээн хэчнээн их хүлээж байна гэж санана аа” гэж билээ.

Би түүнийг сонсож суух үед: “Үгээр хэлж, үзгээр бичиж болох харууслын үгс дотроос хамгийн гунигтай нь ‘Тэгж болох л байсан!’”<sup>1</sup> гэх үгс гэж Жон Гринлиф Виттирийн хэлсэн нь санаанд орж билээ. Ах, эгч нар аа, бид бусдыг хайрлаж, тэдэнд нинжин сэтгэлээр хандсанаараа ингэж харуусахаас зайлсхийж чадна.

Хайрыг инээмсэглэх, гараараа даллан мэндлэх, эелдэг үг хэлэх, магтах зэрэг маш олон арга замаар илэрхийлж болно. Бас бусдын хийж байгаа зүйлийг сонирхож буйгаа харуулах, эелдэг зан, тэвчээрээр зарчмуудыг заах, өвчтэй болон гэртээ байдаг хүмүүсийг эргэж очих зэрэгт торгон мэдрэмжтэй байх нь хайрын илэрхийлэл юм. Эдгээр үг, үйлдлүүд болон өөр олон зүйл хайрыг илэрхийлж чадна.

Америкийн нэрт зохиолч, уран илтгэгч Дэйл Карнеги “ганцаардсан эсвэл санаагаар унаж гутарсан хэн нэгэнд чин сэтгэлээсээ талархсан хэдхэн үг хэлснээр дэлхийг бүхэлд нь . . . аз жаргалтай болгож чадах дотоод сэтгэлийн хүч хүн бүрд байдаг” гэдэгт итгэдэг байв. Тэрээр “магадгүй та өнөөдөр хэн нэгэнд хэлсэн сайхан үгсээ маргааш гэхэд мартаж мэднэ. Харин сэтгэл уяраам сайхан үгийг тань сонссон хүн насан туршдаа тэр үгсийг тань эрхэмлэн нандигнаж явах болно”<sup>12</sup> гэж хэлжээ.

Бид гэр бүлийн гишүүн, найз нөхөд, танил, бүр огт танихгүй хүн байсан ч ялгаагүй яг одооноос, өнөөдрөөс эхлэн Бурханы бүх хүүхдэд хайраа харуулж эхлэх болтугай. Бид өглөө бүр сэрэхдээ бидэнтэй тааралдаж болох хэн нэгэнд хайр, нинжин сэтгэлээ харуулахаар шийддэг байх хэрэгтэй.

Ах, эгч нар аа, биднийг гэсэн Бурханы хайр нь бидний ойлголтоос давсан зүйл юм. Тэрээр энэхүү хайрынхаа улмаас Хүүгээ илгээсэн билээ. Хүү бидэнд мөнх амьдралын боломж олгохын тулд Өөрийн амийг бидний төлөө өгсөн. Бид юутай ч зүйрлэшгүй уг бэлгийг илүү сайн ойлгосноор Мөнхийн Эцэг болон өөрсдийн Аврагчийг мөн бүх хүн төрөлхтнийг хайрлах хайраар бидний зүрх сэтгэл дүүрэх болно. Энэ бүгд биелэх болтугай хэмээн Есүс Христийн ариун нэрээр би чин зүрхнээсээ залбирч байна, амен.

#### ЭШЛЭЛҮҮД

1. Матай 22:36–39.
2. Марк 12:31.
3. 1 Иохан 4:21.
4. Лук 23:34.
5. Зохиолч нь мэдэгдээгүй, Ричард Л.Иванс, “The Quality of Kindness,” *Improvement Era*, 1960 оны 5-р сар, 340.
6. *The Teachings of Spencer W. Kimball*, Эдвард Л.Кимбаллын хэвлэл (1982), 483.
7. “Injured Boy Flown to Safety,” *Daily Sitka Sentinel* (Alaska), 10-р сар, 22, 1981-ийг үзнэ үү.
8. Моронай 7:47.
9. Гордон Б.Хинкли, “Let Love Be the Lodestar of Your Life,” *Ensign*, 1989 оны 5-р сар, 67.
10. Сургаал ба Гэрээ 121:43-ыг үзнэ үү.
11. “Maud Muller,” in *The Complete Poetical Works of John Greenleaf Whittier* (1878), 206; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.
12. Dale Carnegie, in, for example, *Larry Chang, Wisdom for the Soul* (2006), 54.

## Бидэнд зориулсан сургаал

**2** 014 оны 5-р сараас 10-р сарыг дуустал, Мелкизедек Санваар болон Халамжийн Нийгэмлэгийн 4 дэх ням гаргийн хичээлүүдийг 2014 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр өгөгдсөн 1 ба түүнээс дээш хэлсэн үгээр бэлтгэх хэрэгтэй. Гадас, дүүргийн ерөнхийлөгчид өөрсдийн хэсэгтээ ашиглах үгийг сонгох ба бишоп болон салбарын ерөнхийлөгчдөд энэхүү үүргийг даалгаж болно.

Эдгээр хэлсэн үгийг [conference.lds.org](http://conference.lds.org) хаягаар орж, олон хэлээр унших боломжтой.



**Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг**  
Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх

# Үнэлж баршгүй найдварын өв

**Х**үндэт ах, эгч нар аа, та нарын заримыг энэ хуралдаанд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн номлогчид урьсан байх. Эдгээр номлогч та нарыг баптисм хүртэж, Бурхантай гэрээнд орох сонголтоо хийхэд аль хэдийн урьчихсан байж ч болох юм.

Бусад нь Бурхантай аль хэдийн хийсэн гэрээнүүдээ эргэн харж, эцэг, эх, эхнэр эсвэл хүүхдүүдээсээ амьдралынхаа гол утга учрыг болгоосой гэж хүссэн урилгыг хүлээн авсан учраас энд ирсэн байж магадгүй. Намайг сонсож байгаа хүмүүсийн зарим нь Аврагчийг дагахаар буцаж очих сонголтоо аль хэдийн хийчихсэн бөгөөд эргэж ирсэнд тань баярлаж байгаа Түүний баяр баясгаланг мэдэрч байгаа болов уу.

Таны хэн байх мөн хаана байгаа гэдгээс үл хамааран та нарын гарт төсөөлж чадахаас тань илүү олон хүний аз жаргал байдаг. Өдөр бүр, цаг тутам та Бурхантай гэрээ хийх эсвэл Түүнийг дагахыг сонгодог.

Мөнх амьдралын бэлгийг өвлөн авах замынхаа аль ч хэсэгт байсан хүмүүст илүү их аз жаргалд хүрэх замыг үзүүлэх боломж та нарт байгаа. Та Бурхантай гэрээ хийх буюу

хийсэн гэрээгээ дагаснаар таны үлгэр жишээгээр амьдарч болох хүмүүст найдварын өвийг үлдээж буй хэрэг юм.

Та бид ийм өвийн амлалтаар адислагдсан. Би энэ амьдралынхаа аз жаргалын төлөө мөнх бус амьдралдаа уулзаж байгаагүй нэгэн хүнд их өртэй юм. Тэр миний элэнц өвгөдийн нэг билээ. Тэрээр өнчин хүүхэд байжээ. Тэр надад үнэлж баршгүй найдварын өв үлдээсэн бөгөөд түүний хийсэн зарим зүйлийн талаар би хуваалцъя.

Түүнийг Хайнрик Айринг гэдэг байсан. Тэрээр маш чинээлэг гэр бүлд төрж өссөн бөгөөд түүний эцэг Эдвард одоогийн Германд буюу Кобургт маш их хөрөнгөтэй хүн байжээ. Түүний эх Шарлотт Вон Бломбэрг язгууртан байсан ба аав нь Пруссийн хааны газар нутгийг манадаг байлаа.

Хайнрик нь Шарлотт, Эдвард хоёрын ууган хүү байсан бөгөөд Шарлотт 31 настай байхдаа гурав дахь хүүхдээ төрүүлээд нас баржээ. Эдвардын хөрөнгө оруулалт амжилтгүй болж, бүх эд хөрөнгөө алдсаны дараа удалгүй нас барсан байна. Тэрээр ердөө 40 настай

байсан бөгөөд гурван өнчин хүүхэд нь л үлджээ.

Миний элэнц өвөө Хайнрик эцэг эхээ хоёуланг нь алдаад зогсохгүй, дэлхийн асар их өв хөрөнгөө алдсан юм. Түүнд ямар ч мөнгө байгаагүй бөгөөд тэрээр Америк явах нь хамгийн найдвар төрүүлэм зүйл гэж мэдэрсэн тухайгаа тэмдэглэлдээ бичжээ. Тэнд гэр бүл эсвэл найз нөхөд нь байхгүй ч Америк явах нь түүнд найдвар төрүүлж байв. Тэр эхлээд Нью Йорк хот руу явав. Дараа нь Миссуригийн Сэйнт Льюис рүү нүүжээ.

Сэйнт Льюист түүнтэй хамт ажиллаж байсан нэг хүн хожмын үеийн гэгээнтэн байв. Хайнрик түүнээс ахлагч Парли П.Праттын бичсэн нэгэн товхимлыг авчээ. Тэр үүнийгээ уншиж, дараа нь хожмын үеийн гэгээнтнүүдийн талаар мэдэж авч болох бүх зүйлийг судалсан байна. Хүмүүст үзэгдсэн тэнгэр элчүүд болон амьд бошиглогч үнэхээр байсан эсэх мөн үнэнийг хийгээд илчлэгдсэн шашныг олж чадсан эсэхийг мэдэхийн тулд тэр залбирчээ.

Хоёр сарын турш анхааралтай судалж, залбирсны эцэст баптисм хүрт хэмээн хэлж байгаа нэгэн зүүд Хайнрик зүүдэлсэн байна. Миний хүндэлдэг санваартан Виллиам Браун уг ёслолыг гүйцэтгэжээ. Хайнрик борооны усаар дүүргэсэн усан санд 1855 оны 3-р сарын 11-ний өглөөний 7:30-д баптисм хүртсэн юм.

Миний өнөөдөр зааж байгаа зүйлүүд үнэн гэдгийг Хайнрик Айринг мэдэж байсан гэдэгт би итгэдэг. Мөнх амьдралын аз жаргал нь үүрд мөнхөд үргэлжлэх гэр бүлийн харилцаагаар дамжин ирдгийг тэр мэдэж байсан. Хэдийгээр Их Эзэний

аз жаргалын төлөвлөгөөг олж мэдээд удаагүй байсан ч мөнхийн баяр баясгалангийн найдвар нь түүний үлгэр жишээг дагах бусдын чөлөөт сонголтоос шалтгаалдаг гэдгийг тэр мэдэж байсан юм. Мөн түүний мөнхийн баяр баясгалангийн найдвар нь энэ дэлхийд хараахан төрж амжаагүй хүмүүсээс мөн шалтгаалах байв.

Тэрээр манай гэр бүл дэх найдварын өв болгон өөрийнхөө түүхийг үр удамдаа үлдээсэн юм.

Энэхүү түүхийг уншсанаар түүнийг дагахыг хүссэн бид бүгдийн төлөөх түүний хайрыг би мэдэрдэг. Түүний үгсээс үр удам нь тэнгэрлэг гэртээ эргэн харих зам дээрээ өөрийг нь дагахаар сонгоосой гэсэн итгэл найдварыг нь мөн мэдэрдэг. Тэрээр энэ нь ганц том сонголтоор биш харин олон жижиг сонголтоор дамжуулан боломжтой болно гэдгийг мэдэж байсан. Би түүний тэмдэглэлээс эш татан уншъя:

“Би ахлагч Эндрүсийн үг хэлэхийг анх сонссон тэр мөчөөс эхлэн . . . хожмын үеийн гэгээнтнүүдийн цуглаануудад бараг алгасалгүй явсан бөгөөд ингэх нь миний үүрэг байлаа.

Би үүнийг хүүхдүүд маань миний үлгэр жишээг дуурайн дагаж мөн гэгээнтнүүд хамтдаа [цуглаарх] энэхүү чухал үүргийг бүү үл ойшоогоосой гэж хүссэн учраас тэмдэглэлдээ бичиж байна”<sup>1</sup> гэжээ.

Хайнрик ариун ёслолын цуглаан дээр бид Аврагчийг үргэлж дурсан санаж мөн тэд түүний Сүнсийг өөрсөдтэйгөө үргэлж хамт байлгах амлалтаа шинэчилж чадна гэдгийг мэддэг байсан юм.

Тэрхүү Сүнс нь баптисмын гэрээгээ хүлээн аваад ердөө хэдхэн сарын дараа номлолдоо үйлчлэхээр дуудагдахад нь түүнийг дэмжин баталсан юм. Тэрээр индианчуудын газар нутаг хэмээн нэрлэгддэг байсан газар 6 жилийн турш номлолдоо итгэлтэй үйлчилснээр үлгэр жишээгээ өв болгон үлдээсэн билээ. Тэр номлолоос чөлөөлөгдөх захидлаа хүлээн авахын тулд Оклахомагаас

Солт Лэйк хот руу алхаж дараа нь битүү тэрэгний цуваатай нэгдэн бараг 1770 км аялсан гэдэг.

Тун удалгүй түүнийг Бурханы бошиглогч өмнөд Юта руу нүүж ирэхээр дуудсан бөгөөд тэндээс өөрийн төрсөн нутаг болох Германд дахин номлолд дуудагдсан юм. Дараа нь Хайнрик Хойд Мексик дэх хожмын үеийн гэгээнтнүүдийн эзэмшил газруудыг барьж байгуулахад туслуулах Их Эзэн Есүс Христийн төлөөлөгчийн урилгыг хүлээн авсан билээ. Мөн тэрээр Мексикт бүрэн цагийн номлогчоор үйлчлэхээр дахин дуудагджээ. Тэр эдгээр дуудлагаа эрхэмлэн биелүүлсэн юм. Түүнийг Мексикийн Чихуахуа дахь Хуарез колонид нэгэн жижиг оршуулгын газарт оршуулсан билээ.

Би түүнийг болон хийсэн зүйлүүдийг нь эсвэл үр удамдаа зориулсан түүний агуу үйлсийг зарлахын тулд энэ бүхнийг эш татан яриагүй. Түүнийг дуудсан Есүс Христэд үйлчлэх үедээ зүрх сэтгэлд нь байсан итгэл, найдварын үлгэр жишээнд нь талархан хүндэтгэхийн тулд л эдгээрийг эш татсан юм.

Тэрээр Нью Йорк мужийн нэгэн ойн цоорхойд амилсан Христ, Тэнгэрлэг Эцэг хоёр Иосеф Смитэд үзэгдсэн гэдэгт итгэсэн учраас эдгээр дуудлагыг хүлээн авсан. Мөн Их Эзэний сүм дэх санваарын түлхүүрүүд нь гэрээнүүдээ сахиж чадах хангалттай итгэлтэй байгаа гэр бүлүүдийг мөнхөд лацдан холбохын тулд хүч чадлаар дахин сэргээгдсэн гэдэгт итгэлтэй байсан учраас дуудлагуудыг хүлээн авсан юм.

Миний өвөг эцэг Хайнрик Айрингийн адил та нар ариун гэрээнүүдээ хичээнгүй бөгөөд итгэлтэй хийж, дагах замаар мөнх амьдрал руу хөтлөх зам дээрх гэр бүлийнхээ хамгийн эхний хүн нь байж болох юм. Гэрээ бүр үүрэг, амлалтуудтай байдаг. Хайнрикт байсантай адил бид бүгдийн үүргүүд нь заримдаа энгийн, заримдаа хэцүү байдаг. Гэвч үүргүүд нь биднийг Тэнгэрлэг Эцэг болон Түүний Хайрт Хүү, Есүс Христтэй мөн гэр бүлүүд үүрд хамт

амьдрах зам дээр гарахад урагшлуулах зорилготой байдаг учраас тэдгээр нь заримдаа хэцүү байх болно гэдгийг санагтун.

Та нар Абрахамын номон дахь дараах үгсийг санаж байгаа:

“Мөн тэдний дунд Бурхантай адилхан нэгэн зогсож байв, мөн тэрээр өөртэйгөө хамт байсан тэдэнд хэлэв: Бид доошоо явцгаах болно, учир нь тэнд орон зай буй, мөн бид эдгээр материалуудаас авч, мөн дээр нь тэд оршин сууж болох дэлхийг бид хийх болно;

Мөн Их Эзэн, тэдний Бурхан тэдэнд зарлиглах бүх зүйл юуг ч гэсэн тэд хийх нь үү гэдгийг харахын тулд үүгээр бид тэднийг нотлох болно;

Мөн өөрсдийн анхны байдлыг хадгалдаг тэдэн дээр нэмэгдэх болно; мөн өөрсдийн анхны байдлыг хадгадаггүй тэд, өөрсдийн анхны байдлыг хадгалдаг тэдэнтэй хамт нэг хаант улсад алдар сууг олж чадах нь үгүй бөлгөө; мөн өөрсдийн хоёр дахь байдлыг хадгалдаг тэдний тэргүүн дээр алдар суу үүрэг мөн мөнхөд нэмэгдэх болно.”<sup>2</sup>

Өөрсдийн хоёр дахь байдлаа хадгалах нь Бурхантай гэрээнүүд хийж, тэдний биднээс шаарддаг үүргүүдийг хэр итгэлтэй биелүүлэхээс шалтгаалдаг. Амьдралынхаа турш ариун гэрээнүүдийг дагах нь бидний Аврагч, Есүс Христэд итгэх итгэлийг шаарддаг.

Адам, Ева хоёр унасан учраас хүн болгонд өгөгдсөн өвийн хувьд бид уруу таталт, сорилт бэрхшээл, үхэлтэй тулгарах болно. Гэсэн хэдий ч бидний хайрт Тэнгэрлэг Эцэг, биднийг Аврагч Өөрийн Хайрт Хүү, Есүс Христийг бидэнд бэлэг болгон өгсөн. Есүс Христийн Цагаатгалын агуу бэлэг болон адислалыг бүх хүнд боломжтой болгодог өв нь амилуулалтын амлалт болон мөнх амьдралыг төрөх бүх хүмүүнд боломжтой болгодог билээ.

Бурханы бүхий л адислалын хамгийн агуу нь болох мөнх амьдрал нь эрх мэдэл бүхий Түүний үйлчлэгчдээр дамжуулан боломжтой болсон

Есүс Христийн үнэн сүмд байдаг гэрээг хийсэн үед ирэх болно. Уналтын улмаас бид бүгд баптисмын цэвэрлэх хүч нөлөө болон гар тавилгаар Ариун Сүнсний бэлгийг хүлээн авах хэрэгтэй. Эдгээр ёслолыг зохих санваарын эрх мэдэлтэй хүмүүс гүйцэтгэх ёстой. Дараа нь бид Христийн гэрэл болон Ариун Сүнсний тусламжтайгаар Бурхантай хийсэн бүх гэрээгээ, ялангуяа ариун сүмд хийсэн гэрээнүүдээ сахиж чадна. Бурханы хүүхдийн хувьд хүмүүс зөвхөн энэ арга замаар болон энэ тусламжаар л өв хөрөнгөө залгамжлах эрхээ авч чадах юм.

Намайг сонсож буй зарим хүний хувьд энэ нь боломжгүй юм шиг санагдаж болох юм.

Та нар Бурхантай хийсэн гэрээнүүдээсээ татгалзахыг эсвэл гэрээнүүдээ дагахгүй байхыг сонгосон хүүхдүүдийнхээ төлөө шаналж буй эцэг эхчүүдийг харсан. Гэвч эдгээр эцэг эх нь бусад эцэг эхийн туршлагаадаас тайтгарал болон найдварыг олж авч чадна.

Алма болон Мозая хааны хөвгүүд Бурханы гэрээ, зарлигуудын эсрэг гаргасан аймшигт эсэргүүцлээ наманчилсан юм. Залуу Алма өөрийн хүү Кориантоныг ноцтой гэм нүглүүдээсээ эргэн, улам итгэлтэй үйлчилж эхлэхийг хардаг. Мөн Мормоны Номонд зөв шударгыг үзэн яддаг уламжлалуудаа орхин, амар амгаланг тогтоохын тулд үхэхээр гэрээнд орж буй леменчүүдийн гайхамшигийг бичсэн байдаг.

Залуу Алма болон Мозаягийн хөвгүүд дээр тэнгэр элч ирсэн юм. Тэдний эцгүүдийн болон Бурханы хүмүүсийн итгэл, залбирлуудын ачаар тэнгэр элч ирсэн юм. Хүмүүсийн зүрх сэтгэлд хүрч буй Цагаатгалын хүчний жишээнүүдээс та зориг ба тайтгарлыг хүлээн авч чадна.

Их Эзэн биднийг хайртай хүмүүстэй мөнхийн өвөө хүлээн авахад нь туслахаар хичээж байгаа үед найдварын бүхий л эх сурвалжаар хангаж өгсөн. Түүний урилгыг хүлээн авахаас татгалзсан тэдгээр

хүмүүсийг ч гэсэн Түүн рүү цуглуулахыг хичээсээр байх аваас Тэрээр бидэнд амлалтууд өгсөн. Тэдний эсэргүүцэл нь Түүнийг гунигтай болгодог ч Тэр хэзээ ч тэднийг орхидоггүй бөгөөд бид ч бас орхиж болохгүй. Тэрээр биднийг үргэлж хайрласнаараа бидэнд төгс жишээг үзүүлдэг: “Мөн тэрчлэн, тахиа дэгдээхийнүүдээ далавчин дороо цуглуулдаг шиг би та нарыг хичнээн ч удаа цуглуулахсан хэмээв, тийм ээ, Ай Израилын угсааны унасан хүмүүс та нар; тийм ээ, Ай Израилын угсааны хүмүүс та нар, унасан та нар мөн түүнчлэн Иерусалимд орших та нар; тийм ээ, тахиа дэгдээхийнүүдээ цуглуулдаг шиг би та нарыг хичнээн ч удаа цуглуулахсан хэмээв, мөн та нар цугласангүй.”<sup>3</sup>

Бид Тэнгэрлэг Эцэгийн бүх сүнсэн хүүхдийг Түүнд, гэрт нь буцаан авчрах Аврагчийн хувиршгүй хүсэлд найдаж болно. Итгэлтэй эцэг эх, өвөө эмээ, өвөг дээдэс бүр адилхан тийм хүсэлтэй байдаг. Тэнгэрлэг Эцэг, Аврагч хоёр бидний юу хийж болох болон юу хийх ёстойг төгс жишээнүүдээрээ харуулдаг. Тэд хэзээ ч зөв шударга зүйлүүдийг хүчилдэггүй, учир нь зөв шударга зүйлүүд нь сонгогдох учиртай байдаг. Тэд биднийг зөв шударга зүйлүүдийг таних чадвартай болгодог бөгөөд үр жимсүүд нь амттай болохыг бидэнд харуулдаг.

Дэлхий дээр төрсөн хүн бүр зөв, бурууг таньж мэдэхэд тусалдаг Христийн гэрлийг хүлээн авдаг. Бурхан биднийг юу хийхийг хүсэж байгааг эсвэл юуг хориглох хэрэгтэйг Ариун Сүнсний хүчээр ялган танихад маань туслахаар мөнх бус үйлчлэгчдийг илгээсэн юм. Бурхан бидэнд сонголтуудын маань үр дүнг мэдрүүлэн, зөвийг сонгох нь чухал гэдгийг ойлгуулдаг. Хэрэв бид зөвийг сонговол—аз жаргал ирэх болно. Хэрэв бид хилэнцгийг сонговол—харамсал, гашуудал ирэх болно. Эдгээр үр дүн ирэх нь зайлшгүй юм. Заримдаа үр дүн нь ямар нэг зорилгоор хойшлогддог. Хэрэв адислалууд тэр дороо ирдэг

байсансан бол зөвийг сонгох нь итгэлийг хөгжүүлж чадахгүй байхсан. Мөн харамсал нь ихэнхдээ хожуу ирж болох учраас бид нүглийнхээ гэмшил, шаналалын нөлөөнүүдийг мэдрэхээс өмнө нүглүүдээсээ эртхэн өршөөгдөхөд итгэл шаардагдаг юм.

Эцэг Лихай зарим хөвгүүнийхээ болон гэр бүлийнхнийхээ хийсэн сонголтуудад харамсаж байв. Тэрээр Бурханы бошиглогч—зохистой, сайн хүн байсан. Тэр бидний Аврагч, Есүс Христийн талаар үргэлж тэдэнд гэрчилдэг байв. Түүнийг Их Эзэн гэр бүлээ устгалаас аврахын тулд дэлхийн бүх эд хөрөнгөө орхи хэмээн дуудах үед тэр бидэнд дуулгавартай байдал болон үйлчлэлээрээ үлгэр жишээ болсон юм. Амьдралынхаа сүүлчийн өдрүүдэд хүртэл тэр хүүхдүүдээ гэрчилсэн хэвээр байв. Лихайд Аврагчтай адил тэдний зүрх сэтгэлийг болон тэдний гунигтай мөртлөө гайхамшигтай ирээдүйг аль алиныг нь ялган харах хүч чадал байгаагүй ч Лихай гэр бүлээ авралд авчрахын тулд гараа сунгасан хэвээр байсан юм.

Өнөөдөр Эцэг Лихайн сая сая үр удмын төлөөх түүний найдварын учрыг тайлбарлаж байна.

Та бид Лихайн жишээнээс суралцахын тулд юу хийж чадах вэ? Бид нар судраас залбирч мөн анхааралтай судалснаар түүний жишээг харж чадна.

Би та нарыг гэр бүлдээ найдварын өв үлдээхээр хичээх үедээ ойрын болон алсын хараатай байхыг санал болгож байна. Ойрын хугацаанд саад бэрхшээл их тохиолдох бөгөөд сатан бас уруу татах болно. Их Эзэн Өөрийн цагтаа, Өөрийнхөө арга замаар үйлддэг гэдгийг ойлгон, тэвчээртэй мөн итгэлтэй хүлээх зүйлүүд байдаг.

Мөн хайртай хүүхдүүдээ бага байхад нь эртнээс хийж байх зүйлүүд ч бий. Хүүхдүүдээ бага байхад нь өдөр бүр гэр бүлээрээ хамтдаа залбирах, судраас унших, ариун ёслолын цуглаанууд дээр гэрчлэлээ

хуваалцах зэрэг нь амархан бөгөөд илүү үр дүнтэй байдаг гэдгийг сана. Хүүхдүүд тань бидний төсөөлдгөөс ч илүү сүнсэнд мэдрэмтгий байдаг.

Тэд том болохоороо хамт дуулж байсан дуулуудаа санана. Мөн тэд дуунуудыг санахаас илүүтэй судрын болон гэрчлэлийн үгсийг санах болно. Ариун Сүнс бүх зүйлийг тэдэнд сануулна. Гэвч судрууд болон дууллын үгс нь илүү удаан үлдэх болно. Эдгээр дурсамж нь тэднийг хэсэг хугацаанд, магадгүй бүр олон жил мөнх амьдралын гэртээ хүрэх замаасаа хазайн, хэрэн хэсэх үед ч тэднийг буцаж ирэхэд нь туслах болно.

Хайртай хүмүүс маань дэлхийн нөлөөлүүдийг мэдэрч, эргэлзээнүүд нь тэдний итгэлийг ялах үед бид алсын хараатай байх хэрэгтэй. Бидэнд өөрсдийгөө удирдаж, тэднийг хүчирхэгжүүлэх итгэл, найдвар, энэрэл байдаг.

Би үүнийг Бурханы хоёр амьд бошиглогчийн зөвлөхийн хувьд

харсан юм. Тэд бол өөр өөрийн гэсэн онцлогтой хүмүүс. Тэд байнга өөдрөг үзлээ хуваалцдаг юм шиг санагддаг. Хэн нэг нь сүмд байгаа ямар нэгэн асуудлыг гаргаж хэлэх үед тэд байнга “Тийм ээ, Бүх зүйл зүгээр байх болно” гэж хариулдаг юм. Тэд ерөнхийдөө хүмүүсийн сэрэмжлүүлж байгаагаас ч илүү зүйлүүдийг мэдэж байдаг.

Тэд бас Их Эзэний арга замыг ч мөн мэдэж байдаг. Тиймээс тэд Түүний хаант улсад үргэлж найддаг юм. Тэд Бурхан тэргүүнд нь байгааг мэддэг. Тэрээр бүхнээс хүчтэй бөгөөд бүгдэд санаа тавьдаг. Хэрэв та нар Түүнийг гэр бүлийнхээ удирдагч болговол бүх зүйл сайн байх болно.

Хайнрик Айрингийн үр удмуудын зарим нь хэрэн хэсэж байгаа мэт санагдаж болох ч түүний үр удмын олонх нь өглөө 6 цагт урьд нь хэзээ ч уулзаж байгаагүй өвөг дээдсийнхээ төлөө ёслолуудыг гүйцэтгэхээр Бурханы ариун сүм рүү явдаг. Тэд түүний үлдээсэн

найдварын өвийн ачаар тийшээ явдаг. Тэрээр үр удмынхаа олонход хэрэгтэй байсан өвийг үлдээсэн юм.

Биднийг бүх зүйлийг итгэлийнхээ дагуу хийсний дараа Их Эзэн бидний төсөөлж чадахаас ч илүү агуу адислалууд хүртэх найдварыг гэр бүлүүдэд маань өгөх болно. Бид Түүний хүүхдүүд учраас Тэрээр хамгийн сайн сайхныг хүсдэг юм.

Бид бүгд амьд Бурханы хүүхдүүд билээ. Назарын Есүс бол Түүний Хайрт Хүү бөгөөд бидний амилсан Аврагч юм. Энэ бол Түүний сүм. Үүн дотор санваарын түлхүүрүүд байдаг бөгөөд ингэснээр гэр бүлүүд мөнхөд хамт байж чадна. Энэ бол бидний үнэлж баршгүй найдварын өв юм. Би үүнийг үнэн гэдгийг Их Эзэн Есүс Христийн нэрээр гэрчилж байна, амен.

#### **ЭШЛЭЛҮҮД**

1. Хэнри Айрингийн дурсамжууд, 1896 он, typescript, Church History Library, 16–21-ийг үзнэ үү.
2. Абрахам 3:24–26.
3. 3 Нифай 10:5.